



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 718

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд буцалтгүй тусламжаар (БНХАУ-ын Энхтайван хөгжлийн сан) санхүүжүүлж бий болсон, нийт 1,334,400,000.00 (нэг тэрбум гурван зуун гучин дөрвөн сая дөрвөн зуун мянга) төгрөгийн үнэ бүхий Хүүхдийн эмнэлгийн цогцолбор барилга байгууламжийг хавсралтад заасны дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ерөнхий захирал Я.Амаржаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, бүртгэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123007338
35-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 18 дугаар сарын 18 ны/ний өдрийн
718 дугаар тогтоолын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖААР
БАРЬСАН, УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр, төрөл	Хүчин чадал		Ашиглалта д орсон огноо	Балансанд бүртгэх нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансанд бүртгэх нийт үнэ (төгрөг)
		Хэмжих нэгж	Биет хэмжээ			
1	Эмнэлгийн барилга	ор	50	12/25/2020	1,193,651,008.00	1,193,651,008.00
2	Гадна тохижилт, явган зам	м2	80	12/25/2020	38,656.28	3,092,502.00
3	Гадна зогсоол, авто зам	м2	393	12/25/2020	55,458.01	21,794,996.00
4	Гадна цэвэр усны шугам	у/м	61	12/25/2020	181,900.00	11,095,900.00
5	Гадна дулааны шугам	у/м	61	12/25/2020	464,200.00	28,316,200.00
6	Дулааны үзель	ком	1	12/25/2020	26,572,794.00	26,572,794.00
7	Гадна бохир усны шугам	у/м	45	12/25/2020	131,900.00	5,935,500.00
8	Гадна цахилгааны хос шугам	у/м	92	12/25/2020	98,700.00	9,080,400.00
9	Гадна холбооны шугам	у/м	389	12/25/2020	54,300.00	21,122,700.00
10	Гадна гэрэлтүүлэг	ш	2	12/25/2020	540,000.00	1,080,000.00
11	Гадна түшиц ханын эко хавтан	м2	120	12/25/2020	100,000.00	12,000,000.00
12	Сандал хогын сав гэх мэт бусад	ш	2	12/25/2020	329,000.00	658,000.00
НИЙТ ДҮН					1,222,217,916.28	1,334,400,000.00
						(нэг тэрбум гурван зуун гучин дөрвөн сая дөрвөн зуун мянга)